



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж,
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Япон Улс дахь Монгол Улсын Элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 11,724.80 (арван нэгэн мянга долоон зуун хорин дөрвөн доллар наян цент) ам.долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Япон Улс дахь Монгол Улсын Элчин сайд Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг сэлбэг, материалаар худалдах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000041

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 1 дүгээр сарын 28 ны өдрийн
32 дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсаас Япон Улс дахь Элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, данснаас хасч, сэлбэгээр худалдах автомашин

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Сэлбэгээр худалдснаас олох орлогын хэмжээ /доод үнэ/
1	Ниссан Элгранд, Gal 96-04 дугаартай, Арлын дугаар- ALE50-062217	1999/2011	99683	5,622.97	5,622.97	-	800.00
2	Ниссан Бассара, Gal 96-09 дугаартай, Арлын дугаар -JTU30-203287	2002/2011	138877	6,101.83	6,101.83	-	1,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН							
				11,724.80	11,724.80	-	1,800.00
				(арван нэгэн долоон зуун хорин дөрвөн доллар наян цент)	(арван нэгэн мянга долоон зуун хорин дөрвөн доллар наян цент)		(нэг мянга найман зуун)